

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД
БАЙГУУЛЛАГЫН ГАДААД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН
ЕРӨНХИЙ ХҮСНЭГТ (ЗАГВАР)

2023 оны 12 дугаар сарын 11

Улаанбаатар хот

Ерөнхий мэдээлэл		
1.	Байгууллага, нэгж	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс
2.	Тайлан боловсруулсан албан хаагчийн овог нэр, албан тушаал:	Хэвлэл мэдээлэл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Н.Өлзийжаргал
3.	Холбоо барих утас:	11-312785, 99285651, 89477713
Гадаад үйл ажиллагааны тайлан		
Утга		Нийт тоон үзүүлэлт
1.	Гадаад томилолт	1 удаа
2.	Зочид төлөөлөгчид	2 удаа
3.	Албан уулзалт	3 удаа
4.	Олон улсын хурал	<input type="checkbox"/> Цахим <input type="checkbox"/> Танхим
5.	Сургалт, семинар	<input type="checkbox"/> Цахим <input checked="" type="checkbox"/> Танхим
6.	Гэрээ, санамж бичиг	байхгүй

Жич: Гадаад үйл ажиллагааны ерөнхий мэдээллийг тоон байдлаар хүснэгтэд оруулсны дараа дэлгэрэнгүй тайланг фото зургийн хамт хавсаргана

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

М.ЦОГЗОЛМАА

БОЛОВСРУУЛСАН:
ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ,
ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Н.ӨЛЗИЙЖАРГАЛ

**НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД
БАЙГУУЛЛАГЫН ГАДААД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН (ЗАГВАР 1-2)**

НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ГАДААД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН							
I. Гадаад томилолт							
Д/д	Улс, хот	Албан тушаал	Хүний тос	Хугацаа	Зорилго	Төсөв	Үр дүн
1.	БНСУ, Жонбук	НБТСГ-ын Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн дарга С.Саранцэцэг	1	2023.05.08-24	Олон улсын наадамд оролцох	7,055,460 төгрөг	Ази Номхон далайн орнуудын мастеруудын наадмын сагсан бөмбөгийн тэмцээний 50+ эмэгтэйчүүдийн ангилалд "Говийн тэнгэр" багийн ахлагчаар оролцон тэргүүн байрт шалгарсан бөгөөд харилцан туршлага судалсан.
II. Зочид төлөөлөгчид							
1.	БНСУ, Сөүл	Сөүл хотын Жүдо бөхийн холбооны төлөөлөгчид		2023.06.23-25	Арга хэмжээ	1,500,000 төгрөг	"Улаанбаатар гранд slam-2023" жүдо бөхийн олон улсын тэмцээнд оролцогчдод арга хэмжээ зохион байгуулсан.
2.	БНСУ, Сөүл	Нийслэлийн 6-н дүүргийн БТСХ-дын дарга нар	6	2023.11.24-28	Арга хэмжээ		Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотын Жүдо бөхийн холбооны урилгаар "Сөүл цом-2023" жүдо бөхийн тэмцээнд оролцон, ажлын айлчлал хийсэн.
III. Албан уулзалт							
1.	БНСУ, Сөүл	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дарга Ж.Ганболд	1	2023.01.	Уулзалт		БНСУ-ын Сөүл хотын Жүдо бөхийн холбооны ерөнхийлөгчтэй Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дарга Ж.Ганболд уулзаж жүдо бөхийн чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөөний талаар ярилцав.
2.	Япон, Токио	Токио хотын Жүдо бөхийн холбооны дэд ерөнхийлөгч Ватанабе Гунзо тэргүүтэй төлөөлөгчид	6	2023.03.04	Уулзалт		Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Мөнгөншагай Токио хотын Жүдо бөхийн холбооны дэд ерөнхийлөгч Ватанабе Гунзо тэргүүтэй төлөөлөгчдийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүндэтгэлийн танхимд хүлээн авч уулзсан.
3.	БНСУ, Дэгү	Нийслэлийн 6-н дүүргийн БТСХ-дын дарга нар	6	2023.11.28-30	Уулзалт		Дэгү хотын биеийн тамир, спортын салбарын байгууллагууд, нийслэлийн 6 дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагууд цаашид хамтран ажиллах чиглэлээр уулзалт хийв.
IV. Сургалт, семинар, хурал /цахим ба цахим бус/							
1.	Япон улс, Токио хот	Токио хотын Жүдо бөхийн холбооны дэд ерөнхийлөгч Ватанабе Гунзо тэргүүтэй төлөөлөгчид	6	2023.03.03-06	НЗТГ, Япон улсын Токио хотын Захиргааны хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд "Улаанбаатар хотод Японы жүдо бөхийн дасгалжуулагчдын баг ажиллуулах" төслийг хэрэгжүүлэх	1,390,542 төгрөг	Японы Токио хотын Захиргааны Иргэн, соёл, спортын зохицуулах хэлтэс, Токиогийн Спортын сайн үйлсийн корпорацийн Олон улсын солилцооны төсөл, Токио хотын жүдо бөхийн холбооноос ирүүлсэн хуваарийн дагуу 2 өдрийн сургалт, семинарыг удирдан явуулсан.

V. Гадаад арга хэмжээ							
1.	БНСУ, Сөүл	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дарга Ж.Ганболд	1	2023.05. 19-21-	Туршлага судлах		"Улаанбаатар марафон-2023" олон улсын гүйлтийг зохион байгуулахтай холбоотойгоор туршлага судлах зорилгоор ний өдөр хот руу явж туршлага судалсан.
2.	БНСУ, Чүнчонь	Монголын Хөлбөмбөгийн академи	14	2023.06. 07-12	Тэмцээн		"Сун Хюнг Мин олон улсын хүүхэд залуусын найрамдалт хөл бөмбөгийн тэмцээн"-д 14 хүний бүрэлдэхүүнтэй баг тамирчид оролцсон.
3.	Кени, Франц, Япон, Казакстан	Кени улсын-2, Франц улсын-1 Япон улсын-1, Казакстан улсын-1 тамирчин	5	2023.05. 31-06.05	Гүйлтийн тэмцээн	25,620,000 төгрөг	"Улаанбаатар марафон-2023" олон улсын гүйлтэд 4 улсын 5 тамирчин (Кени улсаас-2, Казакстан улсаас-1, Франц улсаас-1, Япон улсаас-1) урилгаар оролцуулснаар марафонд гүйгч, тамирчдын ур чадвар сайжирсан.
4.	Монгол, УБ хот	Баг тамирчид	41 орны 350	2023.06. 23-25	Олимпийн эрх авах тэмцээн		"Монголын жудо бөхийн холбоо Олон улсын жудо бөхийн холбоо /IJF/-ны дэлхийн цуврал болох "Парис-2024" зуны олимпийн наадмын эрхийн оноо олгох "Улаанбаатар их дуулга-2023" тэмцээнийг зохион байгуулж, 41 орноос Монгол Улсын баг тамирчид 3-р байранд орсон.
5.	БНСУ, Сөүл	Монголын жудо бөхийн өсвөрийн баг тамирчид	8	2023.11. 24-28	"Seoul cup" өсвөрийн жудочдын тэмцээн		БНСУ-ын Сөүл хотын Жудо бөхийн холбооны урилгаар "Seoul cup" өсвөрийн жудочдын тэмцээнд оролцсон.
VI. Гэрээ, санамж бичиг							
Д/д	Улс, хот	Гадны байгууллагын нэр, албан тушаал	Төрөл	Огноо	Тэргүү	Гарын үсэг зурсан байгууллагын нэр, албан тушаал	Зорилго/Ур дүн
1.	байхгүй						

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 М.ЦОГЗОЛМАА

БОЛОВСРУУЛСАН:

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

 Н.ӨЛЗИЙЖАРГАЛ

НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС


2023 оны 03 дугаар сарын 06

Улаанбаатар хот

“УЛААНБААТАР ХОТОД ЯПОНЫ ЖУДО БӨХИЙН ДАСГАЛЖУУЛАГЧДЫН БАГ АЖИЛЛУУЛАХ” ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Япон улсын Токио хотын Захиргааны хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд “Улаанбаатар хотод Японы жүдо бөхийн дасгалжуулагчдын баг ажиллуулах” төслийг хэрэгжүүлэх зорилгоор Токио хотын Жүдо бөхийн холбооны дэд ерөнхийлөгч Ватанабе Гунзо тэргүүтэй төлөөлөгчид 2023 оны 03 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд албан ёсны айлчлал хийсэн.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Мөнгөншагай 2023 оны 03 дугаар сарын 04-ний өдөр Токио хотын Жүдо бөхийн холбооны дэд ерөнхийлөгч Ватанабе Гунзо тэргүүтэй төлөөлөгчдийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүндэтгэлийн танхимд хүлээн авч уулзсан.



Уулзалтад Монголын талаас Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Мөнгөншагай, Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дарга Ж.Ганболд, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг – Биеийн тамир, спортын газрын Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн дарга С.Саранцэцэг; Японы талаас Япон улсын Токиогийн Жүдо бөхийн холбооны дэд ерөнхийлөгч, ахлах дасгалжуулагч Ватанабе Гунзо, Токио хотын цагдаагийн газрын дасгалжуулагч, Азийн наадмын 3-н алтан медальт Игуса Тацуаки, Японы Кодокан

жүдо бөхийн хүрээлэн, эмэгтэйчүүдийн дасгалжуулагч, 1985 оны Универсиадын алтан медальт Мукай Микихиро, “Токио-2010” их дуулгын алтан медальт, “Лондон-2012” олимпийн 5-р байрын шагналт, дасгалжуулагч Накай Такахиро, Токио хотын Захиргааны Иргэн, соёл, спортын зохицуулах хэлтсийн гүйцэтгэх захирал, Токиогийн Спортын сайн үйлсийн корпорацийн Олон улсын солилцооны төсөл хариуцсан захирал Сато Норико нар оролцсон.



Японы Токио хотын Захиргааны Иргэн, соёл, спортын зохицуулах хэлтэс, Токиогийн Спортын сайн үйлсийн корпорацийн Олон улсын солилцооны төсөл, Токио хотын жүдо бөхийн холбооноос ирүүлсэн хуваарийн дагуу 2023 оны 03 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд Спортын төв ордны 1 давхарт байрлах Монголын Жүдо бөхийн холбооны Үндэсний шигшээ багийн тамирчдын зааланд зохион байгуулсан.





Семинарын эхний өдөр жүдо бөхөөр сонирхон хичээллэдэг 7 дүүргийн Засаг дарга нарын дэргэдэх жүдо бөхийн өсвөрийн шигшээ багийн 8-14 насны 170-200 тамирчин, жүдо бөхийн 30 гаруй клубын 200 гаруй тамирчин, семинарын 2 дахь өдөр өсвөрийн шигшээ багийн 15-18 насны 120-150 тамирчин, жүдо бөхийн 30 гаруй клубын 200 гаруй тамирчин, нийтдээ 800 орчим өсвөрийн жүдочид оролцсон.





ХЯНАСАН:
ДАРГА

Ж.ГАНБОЛД

МЭДЭЭ НЭГТГЭСЭН:
ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Н.ӨЛЗИЙЖАРГАЛ

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

АЗИ НОМХОН ДАЛАЙН ОРНУУДЫН МАСТЕРУУДЫН НААДМЫН САГСАН БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭНД ОРОЛЦСОН ТУХАЙ

ИЛТГЭХ ХУУДАС

2023 оны 08 дугаар сарын 31

Улаанбаатар хот

Бүгд Найрамдах Солонгос Улсын Жонбук хотноо 2023 оны 05 дугаар сарын 08-24-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Ази, номхон далайн орнуудын мастеруудын 2-р наадамд 71 орны 14177 тамирчид 25 төрлөөр 83 ангилалаар хурд хүч, авьяас чадвараа сорин өрсөлдсөн.

Энэхүү наадамд манай улсаас спортын 16 төрөлд 381 тамирчин оролцсон. 4 жил тутамд явагддаг мастеруудын энэхүү наадамд оролцохоор 35-85 насны манай тамирчид бэлтгэл сургалтаа тогтмол хийж ирсэн нь спортоор дамжиж эрүүл чийрэг, эрч хүчтэй байх, өөрсдийн насны ангилалд тив, дэлхийн хэмжээнд ямар түвшинд хүрсэнээ мэдэх сайхан боломж байлаа.

Уг наадам нь дэлхийн улс орнуудын найрамдал, нөхөрлөлийг бэхжүүлж байгаагаараа онцлог болсон.

Энэхүү наадмын Сагсан бөмбөгийн тэмцээний эмэгтэйчүүдийн 50+ насны ангилалд Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн дарга С.Саранцэцэг ахлагчтай баг амжилттай оролцож багаараа алтан медаль хүртсэн амжилт үзүүлсэн.



Тус наадамд оролцоход Улаанбаатар-Пусан-Сөүл-Улаанбаатар чиглэлийн онгоцны тийзэнд 1,489,000 төгрөг, зочид буудлын зардал 8-н хоногийн 4,170,000 төгрөг, хоолонд 8-н хоногийн 1,390,000 төгрөг, нийт 7,055,460 төгрөгийг зарцуулсан.

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
СПОРТ, НИЙТИЙН БИЕИЙН
ТАМИРЫН ХЭЛТСИЙН ДАРГА

С.САРАНЦЭЦЭГ

НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

“АЗИЙН ӨСВӨРИЙН ЗАЛУУЧУУДЫН СПОРТЫН НААДАМ-2023” АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦСОН ТУХАЙ

ИЛТГЭХ ХУУДАС

2023 оны 08 дугаар сарын 31

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Мөнгөншагайгаар ахлуулсан 23 хүний бүрэлдэхүүнтэй бадминтон, пара бадминтон, ширээний теннис, пара ширээний теннисний баг тамирчид Япон улсын Токио хотноо 2023 оны 08 дугаар сарын 23-29-ний хооронд зохион байгуулагдсан “Азийн өсвөрийн залуучуудын спортын наадам - 2023” арга хэмжээнд амжилттай оролцсон.



Тус наадмын зааврын дагуу Монгол улсын нийслэл Улаанбаатар хотоос гадна Архангай, Дархан-Уул, Орхон, Өмнөговь, Төв, Хөвсгөл аймгаас оролцсон 15-аас доош насны баг тамирчдын бүрэлдэхүүн бадминтоны эрэгтэй 3 тамирчин 1 дасгалжуулагчтай, эмэгтэй 3 тамирчин 1 дасгалжуулагчтай, пара бадминтоны эрэгтэй 1, эмэгтэй 1 тамирчин, 1 дасгалжуулагч, 1 багийн ахлагч;



ширээний теннисний эрэгтэй 3 тамирчин 1 дасгалжуулагчтай, эмэгтэй 3 тамирчин 1 дасгалжуулагчтай, пара ширээний теннисний эрэгтэй 1 тамирчин, 1 дасгалжуулагч, 1 багийн ахлагчтайгаар бүрдсэн.



БАДМИНТОН БОЛОН ПАРА БАДМИНТОНЫ ТӨРӨЛД

“Азийн өсвөрийн залуучуудын спортын наадам”-ын бадминтон болон пара бадминтоны тэмцээнд 12 улс, Японы 5-н муж нийт 17 баг тамирчид бадминтоны 5-н төрлөөр өрсөлдлөө.



Манай Улсаас Архангай, Өмнөговь, Хөвсгөл аймаг болон Улаанбаатар хотын “Ёл” клубын тамирчин, дасгалжуулагч нар бадминтоны өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс шалгаран нийт 11 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон.



Тэмцээний урд өдөр буюу 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдөр Японы Токио хотын дунд сургууль дээр очин Япон улсын ёс заншилтай танилцсан.



Бадминтоны тэмцээн нь 2023 оны 08 дугаар сарын 26-нд эхэлж, манай улсын баг тамирчид эхний хэсэгтээ Сингапур, Малайз, Японы Мияги улстай таарч хэсгээсээ 4-р гарч ирсэн. Ингээд 17 багаас 16 дугаар байрыг эзэлсэн.

Парабадминтоны тамирчин Б.Эрдэнэтунгалаг SL4 ангилалд өрсөлдөж 5 дугаар байранд шалгарсан.

Asia Junior Sports Exchange Games 2023 (Badminton)			
2023ジュニア スポーツ アジア交流大会 (バドミントン)			
Badminton Ranking			
1st place	Fukushima 福島		
2nd place	Jakarta ジャカルタ		
3rd place	Bangkok バンコク		
4th place	Seoul ソウル		
5th place	Miyagi 宮城		
6th place	Hong Kong 香港		
7th place	Beijing 北京		
8th place	Kuala Lumpur クアラルンプール		
9th place	Tokyo-A 東京-A		
10th place	Ibaraki 茨城		
11th place	Singapore シンガポール		
12th place	Manila マニラ		
13th place	Delhi デリー		
14th place	Tokyo-B 東京-B		
15th place	Iwate 岩手		
16th place	Ulaanbaatar ウランバートル		
17th place	Yangon ヤンゴン		
Para Badminton Men SL4 Ranking			
1st place	OGAWA KOKI	小川 航輝	Tokyo/東京
2nd place	HENDRI SAPUTRA	ヘンドゥリ サプトゥラ	Jakarta/ジャカルタ
3rd place	THUYA AUNG	トゥヤ アウン	Yangon/ヤンゴン
4th place	CHENG WILL	チェン ワイ	Hong Kong/香港
Para Badminton Men SU5 Ranking			
1st place	CHOK-UTHAIKUL WATCHARAPHON	チョークウタイクン ワッチャラポン	Bangkok/バンコク
2nd place	AMYRUL YAZID BIN AHMAD SIBI	アミルル ヤジド ビン アフマド シビ	Kuala Lumpur/クアラルンプール
3rd place	JANGID ADBHUT	ジャンギド アドブト	Delhi/デリー
4th place	DELA CRUZ ANTONIO JR.	デラ クルズ アントニオ ジュニア	Manila/マニラ
5th place	NYAMDORJ TUGSBAT	ニヤムドルジ トゥグスバト	Ulaanbaatar/ウランバートル
Para Badminton WOMEN SL4 Ranking			
1st place	SAWADA SHIHO	澤田 詩歩	Tokyo/東京
2nd place	WAN NORAINI BINTI ZAINURIAN	ワン ノライニ ビンティ ザイヌリアン	Kuala Lumpur/クアラルンプール
3rd place	HONASAN MA. CIELO	ホナサン マ シエロ	Manila/マニラ
4th place	NISFI KHOIRU SYABANI	ニスフィ コイル シャパニ	Jakarta/ジャカルタ
5th place	BOLOR-ERDENE ERDENETUNGALAG	ボロル-エルデネ エルデネトンガラガ	Ulaanbaatar/ウランバートル
6th place	KANWAT SAMAIRA	カンワト サマイラ	Delhi/デリー
Para Badminton Women SU5 Ranking			
1st place	NARAMITKORNBUREE WATHINI	ネラミットコーンブリー ワティニー	Bangkok/バンコク

Манай баг тамирчдын хувьд хэдий хожигдол хүлээлсэн ч тамирчид маань тоглолт бүр дээрээ сайжирч илүү зүтгэлтэй оноогоо ахиулж тоглож байгаа нь сайшаалтай сайн байсан.

Дараа жилээс Монголын тамирчдын насыг харж байхад илүү давуу талтай, өмнөх жилийнхээс илүү сайн тоглох нь харагдаж байсан. Багш дасгалжуулагчдын хувьд мөн маш их туршлага хуримтлуулж авсан.

Бадминтон, парабадминтоны баг тамирчдын зүгээс энэхүү тэмцээнд оролцох боломжийг олгосон Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын удирдлага, хамт олонд нийт дасгалжуулагч тамирчдын өмнөөс талархал илэрхийлсэн.

ШИРЭЭНИЙ ТЕННИС БОЛОН ПАРА ШИРЭЭНИЙ ТЕННИСНИЙ ТӨРӨЛД

Тус тэмцээний ширээний теннисний төрөлд 11 орны 16 баг 4 хэсэгт 4 - 4-өөрөө хуваагдан орж өрсөлдсөн.



Монголын баг “С” хэсэгт Сөүл /БНСУ/, Ибаракэ /Япон/, Ивате /Япон/ таарч хэсэгтээ эхний тоглолтоо Ибаракэгийн /Япон/ багтаа хийж хүчтэй өрсөлдөөнийг үзүүлэн 3 : 1 - ийн харьцаатай хожигдсон. Хэсгийн хоёр дахь тоглолтоо Сөүлийн /БНСУ/ багт 3 : 0 харьцаатай хожигдон, хэсгийн сүүлчийн тоглолтоо Иватэгийн /Япон/ багтай хийн 3 : 2-ын харьцаатай хожиж хэсгээсээ 3-р байраар шалгаран 9-12-р байрны төлөө тоглолтонд Яангоны /Мьянмар/ багтай хийн 3 : 1 харьцаатай хожил байгуулж улмаар Манилийн багийг хожсон Делигийн /Энэтхэг/ багтай 9-р байрын төлөөх тоглолтонд 3 : 2 - ын харьцаатай хожигдон 10-р байранд орлоо.

Парагийн
төрөлд оролцсон
Ч.Ганбат 9
тамирчнаас 8-р
байранд орлоо.

Мөн тэмцээний
үеэр Монголын баг
тамирчдыг Шибуюа
дунд сургуультай
танилцах үйл



ажиллагаа зохион байгуулагдлаа.

Тэмцээний эхний өдөр Лондон 2012 оны зуны олимпийн Мөнгөн медальт тамирчин Хирано Саяако /Япон/ тэмцээнд оролцсон бүх баг тамирчид болон Пара тамирчдын техник ур чадварыг үзэн сонирхож, тэдэнд өөрийн үнэтэй зөвөлгөө өгөн, арга туршлагаасаа хуваалцлаа. Энэ удаагийн тэмцээн Монголын ширээний теннисний өсвөрийн тамирчид, багш дасгалжуулагчдын хувьд ширээний теннис өндөр хөгжсөн Япон, Солонгос, Хятад, Сингапур, Хонконг, Тайвань зэрэг орны баг тамирчдын техник, ур чадвар арга барилтай танилцан туршлага хуримтлуулсан ач холбогдолтой тэмцээн боллоо.

Тус нэр хүндтэй арга хэмжээнд оролцоход туслалцаа, дэмжлэг үзүүлсэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаал харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс, Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн хамт олон талархал илэрхийлье.

ХЯНАСАН:

ДАРГА Ж.ГАНБОЛД

МЭДЭЭ НЭГТГЭСЭН:

МЭРГЭЖИЛТЭН Н.ӨЛЗИЙЖАРГАЛ

